



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2017 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 149

Номгон

Г Ээлжит бус хуралдааны тов зарлах тухай Т

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 23 дугаар зүйлийн 23.4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит бус IX хуралдааныг 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 10<sup>00</sup> цагт Баянхонгор сумын төвд зарлан хуралдуулж дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй.

1.1. Аймгийн нийгэм, эдийн засгийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тухай

1.2. Аймгийн 2017 оны төсөвт тодотгол хийх тухай


1.3. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Тэргүүлэгчдээс 2017 онд хийж хэрэгжүүлсэн ажлын тайлангийн тухай

1.4. "Хонгорын хүдэр" ХХК-тай байгуулсан гэрээний хэрэгжилтийн тухай

1.5. Эмийн эргэлтийн сангийн тухай

1.6. Аймгийн хэмжээнд нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа явуулж буй аж нэгжүүдийн тайлангийн тухай

2. Хуралдааны бэлтгэлийг сайтар хангаж, асуудлыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээр урьдчилан хэлэлцүүлэхийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуюн/-д үүрэг болгосугай.



116031